



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И мэйл: ub@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn

2025.05.14 № 02/327
танай _____-ны № _____ -г


НИЙСЛЭЛИЙН АГААР, ОРЧНЫ
БОХИРДОЛТОЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА
Д.МӨНХБААТАР ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд
заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн
хүрээнд "Төрийн хэмнэлтийн тухай хуулийн
хэрэгжилт, үр дүн" сэдэвт нийцлийн аудитыг хийж
гүйцэтгэлээ.

Дээрх аудитаар танай байгууллагад илэрсэн
зөрчлийг арилгах албан шаардлагыг хүргүүлж
байгааг хэрэгжүүлж, тогтоосон хугацаанд
биелэлтийг ирүүлнэ үү.

Хавсралт 1 хуудастай.

ДЭД ДАРГА



Ч.БОЛД

1425030244



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 05 сарын 12 өдөр

Дугаар 459/10210202; 10170196
ЛТМ- 2025/34-11-ЦТА-11А

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд "Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүн" сэдэвт нийцлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар нь "Нийслэлийн Төр захиргааны авто бааз" УТҮГ-тай 2023-2024 онд "Авто машинаар үйлчлэх" гэрээг байгуулж, үйлчилгээний төлбөрт 23,888,660.00 (хорин гурван сая найман зуун наян найман мянга зургаан зуун жаран) төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т "Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аймаг, сум, баг, нийслэл, дүүргийн Засаг даргаас бусад этгээд албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давшан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-т "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давшан гаргахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давшан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллахыг Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын дарга (Д.Мөнхбаатар), ахлах няглан бодогч (Б.Алтантуул) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨНІ:

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Э.ОТГОН

М.ОДГЭРЭЛ

М.ЭРДЭНЭЖАРГАЛ

Б.ЗОЛБАЯР

1 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө,
Г корпус, 4 давхар

1425040581